

МОНГОЛЬСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК  
Институт истории и  
этнологии



РОССИЙСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК  
Институт восточных  
рукописей



МЕЖДУНАРОДНАЯ  
АССОЦИАЦИЯ  
МОНГОЛОВЕДОВ



# КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

## V

Международная конференция  
при поддержке Президента Монголии



19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург- Улан-Батор  
2023

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Ответственный редактор:** Академик С. Чулуун  
**Редакторы-составители:** доктор филол. наук И.В.Кульганек  
доктор (Ph.D) Н.Хишигт  
кандидат филол. наук Д.А.Носов

**Культурное наследие монголов:** Рукописные и архивные собрания. Сборник докладов V международной научной конференции. 19-21 апреля 2021 г. Санкт-Петербург, Россия. СПб.-УБ., 2023 г. -...с.,

Сборник представляет собой собрание докладов V международной научной конференции "Культурное наследие монголов: рукописные и архивные собрания", организованной Институтом восточных рукописей РАН, Институтом истории и этнологии МАН и Международной Ассоциацией монголоведов в г.Санкт-Петербург, 19-21 апреля 2021 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Институт восточных рукописей РАН, 2023 г

© Институт истории и этнологии МАН, 2023 г.

© Международная ассоциация монголоведов, 2023 г

МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИ  
Түүх, угсаатны зүйн  
хүрээлэн



ОХУ-ЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИ  
Дорно дахины гар  
бичмэлийн хүрээлэн



ОЛОН УЛСЫН МОНГОЛ  
СУДЛАЛЫН ХОЛБОО



# МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

## V

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор  
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2021 оны 4 сарын 19-21  
Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург- Улаанбаатар  
2023

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Хариуцлагатай редактор:** Академич С.Чулуун  
**Эмхтгэгч-редактор:** Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек  
Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт  
Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.А.Носов

**Монголчуудын соёлын өв:** гар бичмэл ба архивын баримтын цуглуулга - V. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2021 оны 4 дүгээр сарын 19-21. ОХУ, Санкт-Петербург хот. Санкт-Петербург-Улаанбаатар., 2023 г. ... тал.

Тус эмхэтгэлийг Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос 2021 оны 4 дүгээр сарын 19-21-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо хамтран зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, угсаатны зүй, улс төр, соёлд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2023 г

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2023 г

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2023 г

MONGOLIAN ACADEMY  
OF SCIENCES  
Institute of History and  
Ethnology



RUSSIAN ACADEMY OF  
SCIENCES  
Institute of Oriental  
Manuscripts



INTERNATIONAL  
ASSOCIATION FOR  
MONGOL STUDIES



# CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

V

International Conference  
Under the Patronage of the President of Mongolia



April 19-21, 2021. St. Petersburg

Proceedings

St. Petersburg - Ulaanbaatar  
2023

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Edited and compiled by**

acad. S.Chuluun  
D.Sc.(Philology) I.V.Kulganek,  
Ph.D (History) N.Khishigt,  
Cand.Sc.(Philology) D.A.Nosov

**Cultural heritage of the Mongolis:** manuscripts and archival collections. Papers of the V International Conference, April 19-21, 2021. St.Petersburg. St.Petersburg -Ulaanbaatar 2023, .... pages.

This is a collection of papers, presented at the Fifth International Conference organized by the the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in St. Petersburg on April 19-21, 2021.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Institute of Oriental Manuscripts RAS, 2023 r

© Institute of History and Ethnology MAS, 2023 r.

© International Association for Mongol Studies, 2023 r

## ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ /

## ӨМНӨХ ҮГ / ПРИВЕТСТВИЕ

- Приветствие директора Института восточных рукописей РАН,  
член-корреспондента РАН И.Ф.Поповой 11
- Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлийн мэндчилгээ 13
- Приветствие генерального секретаря международной ассоциации  
монголоведов, академика С.Чулууна 15
- Монгол улсын Их хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд  
Л.Энх-Амгалангийн мэндчилгээ
- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч  
Д.Сумъяабазарын мэндчилгээ

## ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

*Г. Алтансүх.*

Аноним Шибани Нāме дахь монгол хүний нэрийн зарим асуудалд

*Э. Баярчимэг*

Лхаарамба Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” хэмээх  
дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай

*К. И. Бикмаева*

Национальные программы по монгольской письменности  
(монгол бичгийн үндэсний хөтөлбөр) как один из основных  
документов в области языковой политики монголии

*Л. Ганбат*

Ибн Арабшах-ийн “Acāibu’l makdūr” зохиолд нүүдэлчдийн  
байлдах арга, бодлогын тухайд өгүүлсэн нь

*Л. С. Дампилова*

Жанровое разнообразие архивных материалов Монгольской  
экспедиции 1967 года

*И. М. Захарова, М. В. Мандрик*

Экспедиции М.Д. и Н.Д. Бутиных 1870 и 1881 гг. в Китай

*И. В. Кульганек, Н. В. Захарова*

Фотографии о монголии и монголах в Институте восточных  
рукописей РАН

*Э. Мөнхцэцэг*

Монгол улсын Үндэсний Номын сан дахь нэгэн монгол-манж  
толь бичгийн тухай

*Б. Нацагдорж, О. Оюунжаргал*

“Хүрээний хэргийн зүй (庫倫事宜)” хэмээх сурвалжийн тухай

*Д. А. Носов*

Россыпи документов В. А. Казакевича: полевой дневник 1925 г.

*Р. Ю. Почекаев*

Правовые воззрения монголов в пословицах и поговорках

*Э. Пүрэвжав*

Хэлмэгдсэн бүтээлүүд: 1938 оны V сарын 12-ны өдрийн акт бичиг

*Т. Д. Скрынникова*

Сакральность правителя и его ритуальные функции  
(По материалам анонимной Altan tobci)

*М. В. Федорова*

Этнографическая коллекция Д.Э. Ухтомского, привезенная из  
экспедиции в Северную Монголию (1910 г.)

*А. Д. Цендина*

Гадания на кубиках (по материалам квартиры-музея  
Ц.Дамдинсурэна и коллекции Р.Отгонбаатара)

*Б.-Х. Б. Цыбикова*

Локальные особенности устных нарративов бурят о Шоно баторе

*С. Чулуун, Н. Хатанбаатар*

Берестяная грамота, обнаруженная из раскопок монастыря в  
Монгольском гоби

*Т. И. Юсупова*

Монгольский ученый комитет в отзывах российских исследователей

РЕЗОЛЮЦИЯ

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

ЗОХИОГЧДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ



DOI10.48612/IVRRAN/9xpd-ulzp-2h1e

Э. Мөнхиэцэг

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН ДАХЬ НЭГЭН МОНГОЛ-МАНЖ ТОЛЬ БИЧГИЙН ТУХАЙ

*Тус өгүүлэлд Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй нэгэн монгол-манж толь бичгийн тухай өгүүлнэ. Энэ толь бичиг нь нийт 93 хуудастай, тайлбаргүй, орчуулгын толь юм. Толийг үйлдсэн хүний нэр, хэзээ найруулж бичсэн зэрэг тодорхойгүй. Уг тольд зөвхөн «а» үсгээр эхэлсэн 1000 орчим үгсийг цагаан толгойн дэсээр байрлуулсан байна. Энэхүү гар бичмэл толь нь монгол-манж толь бичиг найруулж ирснийг илтгэх бидэнд мэдэгдэж буй хоёр дахь баримт болно.*

*Түлхүүр үгс: гар бичмэл, толь бичиг, а үсэг, монгол толгой үг, манж орчуулга, утга.*

Э.Мунхиэцэг

## ОБ ОДНОМ МОНГОЛЬСКО-МАНЬЧЖУРСКОМ СЛОВАРЕ ИЗ СОБРАНИЯ НАЦИОНАЛЬНОЙ БИБЛИОТЕКИ МОНГОЛИИ

*В статье рассматривается монголо-маньчжурский словарь, который хранится в Монгольской национальной библиотеке. Он является переводным словарем, без толкований. Словарь состоит из одной тетради на 93 листа. В ней отсутствуют дата его написания и имя составителя. Словарь включают в себя более 1000 слов, приводящихся по порядку традиционного монгольского алфавита, которые начинаются только на букву «а». Этот рукописный словарь, как стало известно нам, второе свидетельство существования монголо-маньчжурских словарей.*

*Ключевые слова: рукописный, словарь, буква а, монгольское заглавное слово, маньчжурский перевод, значение.*

Манж нар Хятад орныг эрхшээлдээ оруулан захирсан үеэс улсын албан ёсны хэл манж хэл болж, бүх албан хэргийг манж хэлээр явуулах болжээ. Улс гүрний нийт ард иргэд, төрийн алба хашиж байсан ноёд түшмэдэд манж бичгийг заан сургахын тулд нэн түрүүн толь бичиг, гарын авлагуудыг зохиох хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Толь бичиг зохиох ажил XVIII зууны үед илүү эрчимтэй явагдсан бөгөөд энэ үед хоёр хэл, гурван хэл, дөрвөн хэлний толиудыг бар сийлэн

тархаасны зэрэгцээ, таван хэлний гар бичмэл толийг зохион гаргажээ. Хожим эдгээр толь бичигт тулгуурлан гэрийн сургалт болон хувийн хэрэгцээнд зориулсан манж-монгол, монгол-манж гар бичмэл толь бичгүүдийг эмхэтгэж эхэлжээ. Манж-монгол гар бичмэл толь бичгүүд нь тоо хэмжээний хувьд монгол-манж хэлнийхээс илүү олон болно.

Монгол Улсын Үндэсний номын санд монгол-манж хэлний нэгэн гар бичмэл толь 13806/97 гэсэн дансны дугаартайгаар хадгалагдаж байна.

Энэхүү монгол-манж толь нь (цаашид ГБММ гэх) нийт 1 дэвтэр, 93 хуудастай. Хуудасны хэмжээ 27x13 см. ГБММ толийг бүтээхдээ бор өнгийн муутуу цаасыг цагаан өнгийн мяндсан утсаар үдэж товхин, хар бэхээр бийрээр үйлдсэн бөгөөд хавтсыг тусгайлан ялгаж өгөөгүй. Нэг хуудсанд 6 мөрөөр бичсэн. Дэвтрийн хуудсууд дээр шугам татаагүй. Хуудасны дугаарыг хуудас бүрийн «а» тал буюу толийг товхиж үдсэн хэсгийн голд манж (үгээр) болон хятад тоогоор дугаарлажээ. Жишээ нь, ма. *juwan ilan*, хят. 十三 ‘арван гурав’ г.м. Энэ нь уламжлалт манж-монгол хэлний толь бичгүүдийн [1708, 1717, 1771] дугаарлалтай адил байгаа юм. Толийн нэрийг хавтас болон толийн бичвэрийн аль алинд бичиж тэмдэглээгүй. Тиймээс зөвхөн толийн бичвэрээс энэ толь бичгийг монгол-манж хэлний толь болохыг мэдэх бололцоотой аж. Түүнчлэн тус толийг үйлдсэн хүний нэр, хэзээ зохиож бичсэн зэрэг тодорхойгүй болно.

Энэхүү толийг монгол, манж хоёр хэлээр бичсэн. ГБММ тольд цагаан толгойн дэс дарааллыг баримтлан үгсийг толгойлсон бөгөөд тайлбаргүй, орчуулгын толь болно. Тольд нийт 1000 гаруй толгой үг багтжээ. Эдгээр үгсийг тольд оруулахдаа босоо мөрд бичиж, монгол үгийг эхэнд нь, түүний доор тухайн үгэнд онолдох манж орчуулгыг тавьсан байна. Нэг хуудсанд багтах толгой үгийн тоо 2-8-ын хооронд хэлбэлзэнэ.

Энэхүү толь бичгийн бүтэц, агуулгын зарим онцлогийг доор дэлгэрэнгүй авч үзье.

ГБММ толь дахь бүх үг “а” үсгээр эхэлжээ. Тэдгээрийг үндсэндээ уламжлалт монгол цагаан толгойн дарааллаар, тодруулбал үгсийн “а” үсгийн ард орсон үсгийг баримжаалан толгойлсон. Гэхдээ зарим тохиолдолд цагаан толгойн дэс зөрчигдсөн байна. Зохиогчийн сонгож оруулсан үгсийн байрлалыг тодорхой харуулах үүднээс толийн бүх бичвэрийг дөрвөн хэсэгт хуваах бололцоотой юм.

1. 1r-58r хуудсанд *a* үсгийн араас гийгүүлэгч, эгшиг (C+V) орсон үгс байрласан байна. Үүнд, *ana* — *ani* — *anu* — *aqa* / *aya* — *aqu* /

ayu — aba— abi — abu — asa гэх мэтээр 58r хуудсыг дуустал аya — ayu — age — agi / aki — ara — ari — aru хэмээн үргэлжилжээ. ү үсгийг толилохдоо уг үсгийн өмнө тавьдаг нэмэлт тэмдгийг тавиагүй, үүний улмаас хоёрдугаар үед нь q/γ гийгүүлэгч орсон үгс холилдон байрлажээ.

2. 58r-61r хуудсанд зохиогч эхний хэсэгт (үз.: Хүснэгт 1) оруулаагүй орхигдуулсан үгсийг нэмж, үсгийн дарааллаар байрлуулсан байна.
3. 61a-64b хуудсанд *a* ба *yi*-гийн нийлц буюу *ayi* хос эгшиг орсон үгс байрлажээ. Өөрөөр хэлбэл, *ayi* - *ayiγu* - *ayibu* - *ayisi* - *ayida* - *ayila* - *ayima* - *ayija* - *ayira* - *ayila* - *ayid* - *ayil* - *ayily* – *ayims* буюу эхлээд C+V гэсэн үе, дараа нь нэг (C), эсвэл хоёр гийгүүлэгчээр (C+C) төгссөн үгс орсон байна. Эдгээр бүх үгийг хос эгшгийн дараа байрлах гийгүүлэгчийг харгалзан цагаан толгойн дэсээр толгойлжээ.
4. 64v-93v хуудсанд эхний хэсгийн үгсийг үргэлжлүүлж, цагаан толгойн дэсээр жагсаажээ. Өөрөөр хэлбэл, *a* үсгийн араас нэг юм уу (C), хоёр гийгүүлэгч (C+C) орсон үгс байрласан байна. Үүнд, *ar* — *arγ* — *arb* — *ars* — *arš* — *art* — *arč* — *ark* — *arγ* — *and* — *anj* — *ang* — *aγ* — *aγs* — *aγš* — *aγt* — *aγd* — *aγl* — *aγj* — *asγ* — *adγ* — *ab* — *abs* — *abt* — *abd* — *abl* — *abč* — *abj* — *abq* — *abs* гэх мэтээр *amt* — *amč* хүртэл үргэлжилжээ. Гэвч жагсаалтын эхэнд цагаан толгойн дэсийн төгсгөлөөс үл мэдэгдэх шалтгаанаар эхэнд оруулж байрлуулсан *ar* үеэр эхэлсэн үгс байгааг тэмдэглэе. Үүнээс өөр багахан зөрчлүүд мөн бий. *arγ* - аар эхэлсэн үгс жагсаалтын хоёр ондоо хэсэгт салж орсон, тэдгээрийн ихэнх нь эхэнд бичигдсэн боловч, нэг үгийг *ar* - аар эхэлсэн үгсийн төгсгөлд нэмж оруулжээ. Түүнчлэн хоёр газарт *abs* бүхий үгс оржээ. Гэвч эдгээрийн эхний тохиолдолд зөвхөн хоёрхон үг хамаарах бөгөөд онолдох орчуулгагүй бичигджээ.

1-р хүснэгтэд зохиогч эхний хэсгийг зохиож дуусгасны дараа нэмж оруулсан үгс, ө.х. толь бичгийн хоёр дахь хэсэгт орсон нэмэлт үгсээс (т. 58r-61r) үзүүлэв. Нийт 46 толгой үгийг нэмж, эхний хэсгийн эхэнд өгөгдсөн үгсийн нэгэн адил цагаан толгойн дэсээр байрлуулжээ. Хоёр дахь хэсгийн нэмэлт үгсийг эхний хэсгийнхтэй харьцуулж үзэхэд үг нэмэх хэд хэдэн шалтгаан байсан нь ажиглагдлаа. Эхний хэсгийн толгой үгтэй холбоотой холбоо үг (үз.: Хүснэгт 1, № 1, 2, 6, 7), эсвэл энэ хэсэгт ороогүй орхигдуулсан нэг язгуурт үгс (үз.: Хүснэгт 1, № 3, 4, 5, 8, 9), цөөн

хэдэн шинэ толгой үгийг нэмэн оруулж (үз.: Хүснэгт 1, № 10-13), эсвэл эхний хэсэгт орсон толгой үгсийг цөөн тохиолдолд давтан (үз.: Хүснэгт 1, № 14-15) бичжээ. Үг давтагдсан тохиолдол нь маш цөөн, давтах болсон нь тухайн үгэнд онолдох өөр манж орчуулгыг нэмж оруулах шаардлагаас үүдсэн бололтой. Энэ толийн нэг монгол үгэнд их төлөв хэд хэдэн манж орчуулгыг хадсан байдаг. Энэ тохиолдолд сүүлийнхийг нь тухайн монгол үгийн дор жагсаан бичсэн байна. Онолын хувьд иймэрхүү нэмэлт орчуулгыг үндсэн бичвэрт багтаах (жишээлбэл, босоо мөрийн дунд) боломжтой хэдий ч, зохиогч эхний хэсгийн бичвэрийг эмх замбараагүй болгохгүйн тулд нэмэлт үгсийг тусад нь жагсааж бичихийг илүүд үзсэн бололтой.

№	Нэмж оруулсан үгс (хоёр дахь хэсэг дэх) (т. 58r-61r)			Үгс (эхний хэсэг дэх) (т. 1r-61r)		
	толгой үгс	Орчуулга	хуудасны дугаар	толгой үгс	орчуулга	хуудасны дугаар
1.	<i>ayałjin-u silüsber ögesi kimüi</i>	аалзны шүлсээр өгөөш хиймүй	т. 58v	<i>ayałji</i>	аалз	т. 5r
				<i>ayałjin-u silüsü</i>	аалзны шүлс	т. 5r
2.	<i>ayar-tur ayad</i>	агаарт агаад	т. 58v	<i>ayar</i>	агаар	т. 5r
3.	<i>adali-yi inu</i>	адилыг нь	т. 59v	<i>adali</i>	адил	т. 22r-v
4.	<i>adalisiy</i>	адил шиг		<i>adaliqan-bar ügei</i>	адилханаар үгүй	
				<i>adali nuγud</i>	адилууд	
				<i>adaliqan</i>	адилхан	
				<i>adalisiyamui</i>	адилшаамуй	
5.	<i>adalisiy-i</i>	<i>id.</i>	<i>adalisiy</i>	адил шиг		
			<i>adalidqamui</i>	адилтгамуй		
6.	<i>ayur yeketei</i>	уур ихтэй	т. 58v	<i>ayur</i>	уур	т. 10v
7.	<i>amisqal amisqumui</i>	амьсгал амьсгамуй	т. 60r	<i>amisqul</i>	амьсгал	т. 39v
8.	<i>amisqamui</i>	амьсгамуй	т. 60r			
9.	<i>ayalyulan</i>	аялгуулан	т. 60v	<i>ayalyu</i>	аялгуу	т. 50v
10.	<i>abali</i>	авааль	т. 59r	-	-	-
11.	<i>abiyas</i>	авьяас	т. 59r	-	-	-
12.	<i>amidan tamu</i>	амьдын там	т. 60r	-	-	-
13.	<i>aruuqan</i>	аруухан	т. 61r	-	-	-

14.	<i>amui</i>	амуй	т. 60v	<i>amui</i>	амуй	т. 41r
15.	<i>aγudalmui</i>	уудалмуй	т. 58v	<i>aγudalmui</i>	уудалмуй	т. 5v

Хүснэгт 1. Нэг болон хоёр дахь хэсэгт байрласан нэг ижил үеэр эхэлсэн толгой үгс

ГБММ тольд олон утгат, эсвэл ижил бичлэгтэй нэг манж үгээр орчуулагдсан монгол толгой үг цөөнгүй бий. Уламжлалт манж-монгол толь бичгүүдэд ийм монгол үгсийг онолдох манж үгийнх нь дор таслалаар зааглан, эгнүүлэн бичсэн байдаг, энэ нь манж хэлийг гол болгож зохиосон толь бичгүүдийн хувьд зүй ёсны хэрэг юм. Гэхдээ ийм тохиолдол нэгэн монгол-манж хэлний гар бичмэл тольд гарч буйг тэмдэглэмээр байна.<sup>1</sup> Тус тольд монгол үгийн хажуугаар хэд хэдэн монгол үгийг нэг толгой үг болгон зэргэд бичиж, тэдгээрт онолдох нэг манж үгийг доор нь тавьсан байдаг. Эдгээр хэд хэдэн монгол үгсээ толийн өөр газруудад давтан оруулсан бөгөөд ингэхдээ цагаан толгойн дэсийг харгалзан үг тус бүрийн байвал зохих тухай тухайн толгойд давтан толилжээ. Жишээ нь, *kü*-гээр эхэлсэн үгс орсон газарт үгсийн жагсаалт нь *küliyemüi*, *kürtemüi*, *tosumui*, *ejelemüi*, *edlemüi*, *dayayamui*, *amsumui*, *ülemüi* – ма. *alimbi*; *a* толгойтой үгс байгаа газарт *amsumui*, *küliyemüi*, *barimui*, *ejelemüi*, *edlemüi*, *dayayamui*, *tosumui*, *ülemüi*, *kürtemüi* – ма. *alimbi* гэсэн байдлаар бичигджээ [Баярсайхан 2009. х. 97-108]. ГБММ тольд монгол үг тус бүрийг тус тусад нь цагаан толгойн дэсээр байрлуулсан бөгөөд тэр бүрд нэг ижил манж орчуулгыг хадаж өгсөн байна. Үз.: Хүснэгт 2.

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар
<i>aq-a</i>	<i>da</i>	ах	[т. 2v]	<i>amγulang</i>	<i>elhe</i>	амгалан	[т. 40v]
<i>amasar</i>	<i>da</i>	амсар	[т. 35r]				
<i>aqamad</i>	<i>da</i>	ахмад	[т. 58r]				
<i>aγarča</i>	<i>da</i>	аарц	[т. 58v]				
<i>abali</i>	<i>da</i>	авааль	[т. 59r]	<i>alyur</i>	<i>elhe</i>	алгуур	[т. 81r]
<i>aγimay-un noyan</i>	<i>da</i>	аймгийн ноён	[т. 63v]				
<i>alda</i>	<i>da</i>	алд	[т. 83v]				

Хүснэгт 2. Нэг ижил манж үгээр орчуулагдсан монгол толгой үгс

<sup>1</sup> Энэхүү толь бичиг нь МУИС-ийн Монгол хэл шинжлэлийн тэнхимд хадгалагдаж байна. Тус тольд дансны дугаар байхгүй болно.

Эсрэгээрээ, нэг монгол үгийг ойр төстэй утга илтгэх өөр өөр манж үгээр орчуулсан тохиолдол ГБММ толь бичигт тааралдав. Энэ тохиолдолд онолдох бүх манж орчуулгыг нь монгол үгийн доор салгалгүй хамт бичсэн бөгөөд монгол хэлийг гол болгож зохиосон бүхий л толь бичгийн хувьд энэ нь зүй ёсны хэрэг билээ. Үз.: Хүснэгт 3.

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар
<i>Atar</i>	<i>yabi,</i>	атар	[т. 23г]	<i>amur</i>	<i>fu nimaha</i>	амар	[т. 41v]
	<i>šunehe,</i>						
	<i>dooran,</i>						
	<i>yabigan</i>				<i>elhe</i>		

Хүснэгт 3. Хэд хэдэн манж үгээр орчуулагдсан монгол толгой үгс

ГБММ тольд нэг ижил утга илтгэдэг, өөр өөрөөр бичигддэг монгол үгсийг энд тэнд салгаж оруулалгүй, цагаан толгойн дэсээр ар араас нь (бие даасан толгой үг шиг) цувуулан бичсэн байна. Ингэж бичихдээ тухай тухайн хувилбар бүрд манж орчуулгыг онолдуулан тавьжээ. Ийм үгс тольд цөөнгүй байгаа юм. Үз.: Хүснэгт 4. Жишээ нь:

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар
<i>ama</i>	<i>angga</i>	ам	[т. 34v]	<i>araddayiki</i>	<i>urseiingge</i>	ардынх	[т. 54v]
<i>am-a</i>	<i>angga</i>		[т. 34v]	<i>arad-un ki</i>	<i>urseiingge</i>		[т. 54v]

Хүснэгт 4. Хэд хэдэн хувилбараар бичигддэг монгол толгой үгс

Ийм онцлогийг ГБММ тольд гарч буй үгсийн манж орчуулгаас мөн олж харах боломжтой. Гэхдээ ийм тохиолдол маш ховор. Энэ тохиолдолд манж үгсийн өөр өөр бичлэгийг харгалзах толгойн үгийнх нь дор эгнүүлэн жагсаажээ. Үз.: Хүснэгт 5.

толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар	толгой үг	манж орчуулга	крилл монгол хөрвүүлэг	хуудасны дугаар
<i>alayčin</i>	<i>alhata,</i> <i>alhasin,</i> <i>alha</i>	алагчин	[т. 29v]	<i>ajiry-a</i>	<i>ajirgan,</i> <i>ajirhan</i>	азарга	[т. 48г]

Хүснэгт 5. Манж үгсэд гарч буй хэд хэдэн бичлэгийн хувилбар

Түүнчлэн ГБММ тольд зарим толгой үгийн дараа тэдгээр үгээр эхэлсэн холбоо үг, нийлмэл үг, эсвэл хоршоо үгийг оруулсан байдаг. Ийм үг арав орчим байна. Үүнд, «уул» (мо. *aγula* – ма. *alin*), «уушги» (мо. *aγuski* – ма. *ufuhu*), «алаг» (мо. *alayu* – ма. *alha*), «ам» (мо. *ama* – ма. *angga*), «амь» (мо. *amin* – ма. *ergen*), «ачлалт» (мо. *ačilaltu* – ма. *hoyoošun*), «айлтгах» (мо. *ayiladqaqu* – ма. *wesimbure*), «алт» (мо. *altan* – ма. *ayisin*). Ихэнх холбоо үг нь «алт» хэмээх үгэнд өгөгджээ. Эдгээр үгийг бүгдийг нь бие даасан толгой үгийн нэгэн адил тольд оруулж, «алт»-ын ард орсон хоёр дахь үгээр баримжаалан, цагаан толгойн дэсээр дараалуулжээ.

Орчин цагийн монгол хэлний толь бичгүүдэд «алт» гэсэн үг оролцсон олон холбоо үг орсон байдаг ч, ГБММ толь дахь жагсаалт нь бүрэлдэхүүний хувьд ялгаатай байгааг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр холбоо үг нь гурав ба таван хэлний зүйл хуваасан манж хэлний толь бичгүүдэд мөн орсон, гэсэн ч тэдгээрийг сэдвийн хувьд өөр өөр зүйлд байрлуулсан байдаг учраас хайж олоход бэрхшээлтэй байдаг. Үүнтэй холбогдуулж тэмдэглэхэд, монгол хэлний зарим хуучны тайлбар тольд холбоо үгсийг толгой үгийн үүргээр оруулсан бол [Šayja 1994; Лувсандэндэв 1959-1966], заримд нь толгой үг болгоогүй, үгийн үүрийн дотор багтаасан байдгийг дурдууштай.

Холбоо үгсийн жагсаалтын ихэнхийг ургамал, шувуу, од эрхэс, эзэн хааны ордны алтаар хийсэн янз бүрийн эд зүйлсийг тодотгосон үгс эзэлж байна. Эдгээр үгийг крилл монгол руу хөрвүүлэхдээ ургамлын нэр томьёоны толь [Мижиддорж 1973; Өлзийхутаг 1984], монгол хэлний товч тайлбар толийг [Цэвэл 1966] ашиглав.

«Алт» (мо. *altan*, ма. *ayisin*) хэмээх үг оролцсон бүх холбоо үгийг доор жагсаан үзүүлье.

- *altan artu körüsü* ‘алтан арт хөрс’, *altan elgügürtü külis* ‘алтан өлгүүрт хүлс’, *altan ukiyal-un γadur-a* ‘алтан угаалын гадар’, *altan üsüg-ün nom-un küriy-e* ‘алтан үсгийн номын хүрээ’, *altan üy-e-tü ča(m)čuy* ‘алтан үет цацаг’, *altan nidütü ularu* ‘алтан нүдэт улар’, *altan nidün biljūuqai* ‘алтан нүдэн бялзуухай’, *altan nilbuyuur* ‘алтан нялбуур’, *altan qongqari* ‘алтан хонхорь’, *altan balta süke* ‘алтан балт сүх’, *altan bojiry-a* ‘алтан божирго’, *altan sandali* ‘алтан сандал’, *altan soličal tulyurun üsüg* ‘алтан сольцол тулгарын үсэг’, *altan daγaqu osei ildü* ‘алт дагах өшөө илд’, *altan tosquγur čorgilqu* ‘алтан тосгуур цоргилох’, *altan longqu* ‘алтан лонх’, *altan anasi odun* ‘алтан анааш од’, *altan melekei tulyarun*

*üsüg* ‘алтан мэлхий тулгарын үсэг’, *altan mörin-dü kigiri* ‘алтан мөрөнд хиур’, *altan čögürsü saba* ‘алтан цүүрс сав’, *altan küjin-ü bayburi* ‘алтан хүжний багвар’, *altan kögürig* ‘алтан хөөрөг’, *altan dan seüke* ‘алтан дан сүйх’, *altan tüsilgetü sandali* ‘алтан түшилгэт сандал’, *altan sirdü ile seüke* ‘алтан ширт ил сүйх’, *altan jügür* ‘алтан жигүүр’, *altan julai* ‘алтан зулай’;

- *altan utasu* ‘алтан утас’, *altan utasu torγumui* ‘алтан утас торгомуй’, *altan oriyangγu čečeg* ‘алтан ороонго цэцэг’, *altan γadasu odun* ‘алтан гадас од’, *altan qačar* ‘алтан хацар’, *altan qariyačai* ‘алтан хараацай’, *altan qumaki čečeg* ‘алтан хумхи цэцэг’, *altan γuryul dai* ‘алтан гургалдай’, *altan qunday-a čečeg* ‘алтан хундага цэцэг’, *altan badir čečeg* ‘алтан бадир цэцэг’, *altan badm čečeg* ‘алтан бадам цэцэг’, *altan biljuuqai čečeg* ‘алтан бялзуухай цэцэг’, *altan seyimekeyileg čečeg* ‘алтан сиймхийлэг цэцэг’, *altan sirkegtü torγ-a* ‘алтан ширхэгт торго’, *altan takiy-a* ‘алтан тахиа’, *altan dusul čečeg* ‘алтан дусал цэцэг’, *altan luutu buu* ‘алтан луут буу’, *altan lu terege* ‘алтан луу тэрэг’, *altan čegečeiükei* ‘алтан цэгцүүхэй’, *altan curbadai* ‘алтан цуравдай’, *altan jiyasu* ‘алтан загас’, *altan jula čečeg* ‘алтан зул’, *altan жүрjei* ‘алтан жүрж’, *altangqu čečeg* ‘алтанхуа цэцэг’.

ГБММ тольд үйл үгийн толь бичгийн хэлбэрийн (-*mui*<sup>2</sup>) зэрэгцээ үйл үгийн бусад хэлбэрийг мөн оруулсан байна. Нэг үйл үгэнд дагуулсан бүтээврийн нийт тоо 1-6-ын хооронд хэлбэлзэж байна. Энэ онцлогийг мөн Чин улсын үед зохиогдсон манж-монгол хэлний толь бичгүүдээс хялбархан олж харах боломжтой. Тиймээс ГБММ тольд энэхүү уламжлал тусгагдсан болох нь тодорхой байна. Жишээ болгон толь бичгээс хоёр үйл үгийг сонгож 6-р хүснэгтэд үзүүлэв.

	Хэлбэрүүд	мо.	ма.	мо.	ма.
		<i>abla-</i> ‘авла-’	<i>abla-</i> ‘авла-’	<i>abira-</i> ‘авир-’	<i>tafa</i> ‘авир-’
1.	мо. <b>-<i>mui</i><sup>2</sup></b> , ма. <b>-<i>mbi</i></b> (IMPF.FINT)	<i>abla-mui</i>	<i>abla-mbi</i>	<i>abari-mui</i>	<i>tafa-mbi</i>
2.	мо. <b>-<i>lča</i><sup>2</sup>-<i>mui</i><sup>2</sup></b> , ма. <b>-<i>ndu-mbi</i></b> (COOP-IMPF.FINT)	<i>abla-lča-mui</i>	<i>abla-ndu-mbi</i>	<i>abari-lča-mui</i>	<i>tafa-ndu-mbi</i>
3.	мо. <b>-<i>γul</i><sup>2</sup>-<i>mui</i><sup>2</sup></b> , ма. <b>-<i>bu-mbi</i></b> (CAUS-IMPF.FINT)	<i>abla-γul-mui</i>	<i>abla-bu-mbi</i>	<i>abari-γul-mui</i>	<i>tafa-bu-mbi</i>
4.	мо. <b>-<i>ldu</i><sup>2</sup>-<i>mui</i><sup>2</sup></b> , ма. <b>-<i>nu-mbi</i></b> (REC-IMPF.FINT)	<i>abla-ldu-mui</i>	<i>abla-nu-mbi</i>	<i>abari-ldu-mui</i>	<i>tafa-nu-mbi</i>



5.	мо. <i>-r-a<sup>2</sup> + od-mui</i> , (DER од-IMPF.FINT) ма. <i>-na-mbi</i> (DER-IMPF.FINT)	<i>abla-r-a</i> <i>odmui</i>	<i>abla-na-</i> <i>mbi</i>	<i>abari-r-a</i> <i>odmui</i>	<i>tafa-na-mbi</i>
6.	мо. <i>-r-a<sup>2</sup> + ire-mui<sup>2</sup></i> , (DER ир-IMPF.FINT) ма. <i>-nji-mbi</i> (DER-IMPF.FINT)	<i>abla-r-a</i> <i>iremüi</i>	<i>abla-nji-</i> <i>mbi</i>	<i>abari-r-a</i> <i>iremüi</i>	<i>tafa-nji-mbi</i>
7.	мо. <i>-ba<sup>2</sup></i> , ма. <i>-ha<sup>3</sup> / -ka<sup>3</sup> / -ngka</i> (PERF.PART)			<i>abari-ba</i>	<i>tafa-ka</i>

Хүснэгт 6. Өөр өөр бүтээврээр хэлбэржсэн үйл үгс

Дээр дурдсан үйлийн хэлбэрүүдээс гадна нэр үгийг олон тооны хэлбэрээр хэлбэржүүлэн тольд оруулсан байдаг. Жишээ нь, *abay-a egeci* ‘авга эгч’ — *abay-a egeci nar* ‘авга эгч нар’, *abay-a nar* ‘авга нар’, *abay-a berged* ‘авга бэргэд’, *abay-a kürgen aq-a nar* ‘авга хүргэн ах нар’. Түүнчлэн *ali* ‘аль?’ хэмээх төлөөний үгэнд зарим тийн ялгалыг залгаж *ali-ača* (ABL), *alin-i* (ACC), *alin-dur* (DAT), мөн ‘арав’ гэсэн тооны нэр (мо. *arban*, ма. *juwan*), түүний *arbaduyar* ‘аравдугаар’, *arbayula* ‘арвуулаа’, *arbayad* ‘арваад’, *arban* ‘арав’, *arbanta* ‘арвантаа’ хэмээх хэлбэрүүдийг бие даасан толгой үгийн түвшинд авч үзжээ.

ГБММ толийг зохиогч тольдоо монгол үгсийг манж орчуулгын хамт нягт нямбай, тодорхой эрэмбэ дарааллаар толилуулсан байгаагаас харахад бичиг үсгийн өндөр боловсролтой хүн байсан нь тодорхой байна. Түүний бичлэгийн онцлогоос дурдвал *γ*, *n* үсгүүд нь дуудлагыг ялгах нэмэлт тэмдэггүй, *č* ба *ǰ*, *γ* ба *ν* гийгүүлэгч үсгүүд нь ижил байдлаар бичигдсэн бөгөөд эдгээр нь 17 дугаар зууны монгол хэлний бичгийн дурсгалд түгээмэл тохиолддог нийтлэг онцлог юм.

Толь бичигт алдаатай бичсэн, нямбай хандаагүй тохиолдол мэр сэр байна. Тухайлбал, монгол хэлний *ани* хэмээх хамаатуулах нөхцөлийг *aniu* гэж буруу бичсэн [т. 2r], *adaliqan-bar ügei* ‘адилхан бэр үгүй’ гэдэг үгсэд орсон *l* гийгүүлэгчийн эврийг бичээгүй [т. 22r], түүнчлэн *ablaldumui* ‘авлалдмуй’ [т. 15r] болон *aburamui* ‘авармуй’ [т. 18r] хэмээх үгс дэх *-mui* бүтээвэрт орсон *m* үсгийн махбодийг буруу тийш чиглүүлж бичсэн, үүнээс болж эдгээр үгийг *ablaldului*, *aburalui* гэж уншихад хүрч байна. Зохиогчийн хайнга хандсаныг илэрхийлэх нэг том нотолгоо бол 79r-р хуудсанд монгол үгсийн манж орчуулгыг орхигдуулж, бичээгүй байгаа явдал. Тодруулж хэлбэл, тус хуудсанд буй нийт 8 монгол толгой үгэнд (*adqumal* ‘атгамал’, *aba* ‘ав’, *ab adali* ‘ав адил’, *ab ariyun* ‘ав ариун’, *ab sab* ‘ав сав’, *abqu* ‘авах’, *absa* ‘авс’, *absalamui* ‘авсалмуй’) манж орчуулгыг хийж дагалдуулаагүй байна.

Энэхүү монгол-манж хэлний толийн нэг дэвтэрт хийсэн судалгаанаас ажиглахад тус толь бичиг нь зөвхөн «а» биш, монгол цагаан толгойн бусад үсгээр эхэлсэн үгсийг багтаасан олон дэвтрээс бүрдсэн байх магадлалтай гэсэн дүгнэлтийг хийж болмоор байна. Толийн гарчиг, зохиогчийн нэр, зохиогдсон цаг хугацаа тодорхойгүй зэрэг нь энэ таамаглалыг давхар баталж байгаа юм. Учир нь ийм төрлийн мэдээллийг толийг зохиож дууссаны дараа буюу толийн төгсгөлд бичдэг уламжлалтай.

Зөвхөн эхний дэвтэр байгаа тухайд, толь бичиг зохиохоор төлөвлөсөн боловч төлөвлөсөндөө хүрч, бүрэн толь болгож чадаагүй байхыг үгүйсгэх аргагүй гэсэн саналыг дэвшүүлэх боломжтой байна.

Аль нь ч байсан толийн цаас, бичгийн хэв, дугаарлалт, цөөн тооны алдаа мадаг болон толь бичигт нэр байхгүй зэргээс үзвэл толь бичгийг бичиг үсгийн боловсролтой хүн хувийн хэрэгцээндээ зориулж үйлдсэн нь илэрхий байгаа бөгөөд, гар бичмэл толийг манж-монгол толь бичигт суурилан зохиосон гэж үзэх боломжийг өгч байгаа юм.

Мөн энэ толь бичиг, түүний бүтэц, агуулгыг боловсруулахдаа ул суурьтай, сайтар нягтлан шинжилж хандсан болохыг хэлж болно. Нөгөөтэйгүүр, энэ толь бичиг бүрэн бус тул дээр өгүүлсэн баримтад тулгуурлан бүрэн дүүрэн дүгнэлт хийх боломжгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Одоогийн байдлаар маш цөөн тооны монгол-манж толь бичиг бидэнд мэдэгдэж байна. Энэхүү гар бичмэл толь нь монгол-манж хэлний толь бичиг зохиогдож байсныг илтгэх хоёр дахь баримт болно. Тиймээс уг толь бичиг нь монгол толь бичгийн судлалд сонирхолтой хэрэглэгдэхүүн болох билээ.

### Товчилсон үгс

ГБММ – гар бичмэл манж-монгол толь

ма. – манж

мо. – монгол

хят. – хятад

ABL – гарахын тийн ялгал

ACC – заахын тийн ялгал

CAUS – үйлдүүлэх хэв

COOP – хамтран үйлдэх хэв

DAT – өгөх оршихийн тийн ялгал

DER – үг бүтээх дагавар

IMPF.FINT – одоо цагийн хэлбэр

PERF.PART – өнгөрсөн цагт үйлт нэр  
REC – харилцан үйлдэх хэв

## Ном зүй

### Сурвалж

Монгол-манж толь бичиг. МУҮНС. Монгол судлал, гар бичмэл номын фонд.  
Д/д 13806/97.

*Han-i araha manju gisun-i buleku bithe* «Хааны бичсэн манж үгний толь бичиг» (1708). Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Манж номын хөмрөг. Шифр С 48.

*Han-i araha manju monggo gisun-i buleku bithe* «Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг» (1717). Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Монгол номын хөмрөг. Шифр F 319.

*Han-i araha ponggime togtobuha manju gisun-i buleku bithe*; хят. Yuzhi zengding Qingwen jian (御製增訂清文鑑) «Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг». Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Манж номын хөмрөг. Шифр С 29.

### Ном ба өгүүлэл

Баярсайхан 2009: *Баярсайхан М.* Монгол манж толь бичгийн уламжлал дахь нэгэн дурсгал //Acta Mongolica, Centre for Mongol Studies, Dedicated to the 80<sup>th</sup> Birthday of professor Igor de Rachewiltz. 2009. Volume 9(320). X. 97-108.

Лувсандэндэв 1959: *Лувсандэндэв А.* Misig., Batu-Včir. Gucin jirγuyatu tayilburi toli // 1959-1966. Corpus Scriptorum Mongolorum. Instituti Linguae et Litterarum Comiteti Scientiarum et Educationis Altae Reipublicae Populi Mongoli. УБ., ШУДБХ-ийн Эрдэм шинжилгээний хэвлэлийн газар. 1959. Т-I, fasc.1-2. 23 х, 48 х; 1960 - Т-I, fasc.3-7. 28 х, 37 х, 45 с, 43 х, 60 х; 1961 - Т-I, fasc.8-12. 32 х, 36 х, 41 х, 39 х, 35 х; 1966 - Т-I, fasc.13. 45 х; 1962 - Т-I, fasc.14. 47 х.

Мижиддорж 1972: *Мижиддорж Го.* Монгол-орос-латин-төвд-хятад хэлээр хавсарсан ургамлын нэр томьёо (Ботаническая терминология монгольско-русско-латинско-тибетско-китайская) //Улсын нэр томьёоны комиссын мэдээ. № 89-90. ШУА. УБ., 1972.

Өлзийхутаг 1984: *Өлзийхутаг Н.* Бүгд Найрамдах Монгол Ард улсын гуурст ургамлын латин-монгол-орос нэрийн толь (Латинско-монгольско-русский словарь названий таксонов сосудистых растений Монгольской Народной Республики). Улсын нэр томьёоны комиссын мэдээ. № 129-133. ШУА. Улаанбаатар., 1984.

Цэвэл 1966: *Цэвэл Я.* Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар., 1966.

Šaγja 1994: *Šaγja.* Eriküy-e kilbar bolγan jokiyaγsan mongγol ügen-ü tayilburi Ćindamani-yin erike. Begejin. 1994.